



Дэлхийн эрүүл
мэндийн байгуулга

Глобаль Сангийн дэмжлэгтэй
ДОХ, Сүрьеэгийн Төсөл

Халдварт Өвчин
Судлалын Үндэсний Төв

ЭМЭНД МЭДЭРЭГ СҮРЬЕЭГЭЭР ӨВЧИЛСӨН ХҮМҮҮСИЙН ӨВРИЙН ЛАВЛАХ

Улаанбаатар
2012

ЭМЭНД МЭДРЭГ СҮРЬЕЭГЭЭР ӨВЧИЛСӨН ХҮМҮҮСИЙН ӨВРИЙН ЛАВЛАХ

Агуулга

I.Танилцуулга

- Сүрьеэ өвчин гэж юу вэ?
- Монгол улсад сүрьеэгийн өвчин яагаад тулгамдсан асуудал болж байна вэ
- Сүрьеэ өвчин хэрхэн тархдаг вэ?
- Сүрьеэгийн халдварлалт гэж юу вэ?
- Сүрьеэгийн өвчлөл гэж юу вэ?
- Сүрьеэгийн халдварлалт болон сүрьеэгийн өвчлөлийн ялгаа

II. Сүрьеэгийн халдвар

- Туберкулины сорил гэж юу вэ?
- Асуулт, хариулт
- Сүрьеэгийн халдвартай бол сүрьеэгээр өвчлөхөөс хэрхэн өөрийгөө хамгаалах вэ?

III.Сүрьеэгийн өвчлөл

- Сүрьеэг хэрхэн эмчлэх вэ?
- Сүрьеэгийн эмчилгээний үед илрэх гаж нөлөө ямар байдаг вэ?
- Яагаад сүрьеэгийн эмчилгээг тогтмол уух шаардлагатай вэ?
- ДОТС гэж юу вэ?
- Сүрьеэгийн эмээ уухыг мартаггүйн тулд яах хэрэгтэй вэ?
- Сүрьеэ өвчин тархахаас хэрхэн сэргийлэх вэ?
- Дахин сүрьеэгээр өвчлөхөөс хэрхэн сэргийлэх вэ?

Танилцуулга

Сүрьеэ гэж юу вэ?

Сүрьеэ өвчин нь сүрьеэгийн нян (*Mycobacterium tuberculosis*)-гаар үүсгэгддэг халдварт өвчин юм. Энэ нян нь ихэвчлэн уушгийг сонгомлоор, мөн бөөр нуруу тархийг гэмтээнэ. Хэрвээ сүрьеэ өвчнийг эмчлүүлэхгүй байвал үхэлд хүргэнэ.

Сүрьеэ өвчин нь уушигны халдвартай хэлбэрийн сүрьеэтэй өвчтнөөс бусад хүнд агаараар дамжин халдварладаг. Халдвартай хэлбэрийн сүрьеэтэй хүн ярих, ханиах, найтаах, дуулах үед сүрьеэгийн нян агаарт цацагдаж, түүний ойр орчимд байсан эрүүл хүн энэхүү сүрьеэгийн нян агуулсан агаараар амьсгалснаар халдвар авна. Хэдий тийм боловч сүрьеэгийн халдвар авсан хүн бүр сүрьеэгээр өвчлөхгүй. Үүнийг сүрьеэгийн халдварлалт гэж хэлнэ. Сүрьеэгийн халдвартай хүмүүс ямар нэг зовиур илрэхгүй, бусад хүнд халдвар тараахгүй. Сүрьеэтэй хүн аль болох эмнэлгийн тусламжийг эрт авбал бүрэн эдгэрч чадна.

Монгол улсад сүрьеэ өвчин яагаад тулгамдсан асуудал болж байна вэ?

Сүрьеэ өвчин нь дэлхий нийтийн нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлын нэг хэвээр байна. Сүрьеэгийн үүсгэгчийг нээснээс хойш 120 гаруй, сүрьеэгийн эсрэг эхний эмүүд нээгдсэнээс хойш 70 шахам жил болж байгаа ч энэ өвчний халдвар тархаж, хүмүүс нас барсаар байна.

Эмэнд мэдрэг сүрьеэгээр өвчилсөн хүмүүсийн өврийн павлах


Манай улсад сүүлийн жилүүдэд дунджаар жил бүр 4000 гаруй сүрьеэгийн шинэ тохиолдол бүртгэгдэж байгаа нь ДЭМБ-ын Номхон далайн баруун бүсийн өвчлөл өндөртэй 7 орны тоонд орж байна.

Сүүлийн жилүүдэд сүрьеэгийн эсрэг хэрэглэдэг үндсэн эм болох изониазид, рифамицинд дасалтай нянгаар үүсгэгдсэн эмэнд тэсвэртэй сүрьеэ тархах болсноор дэлхийн нийтийн хэмжээнд сүрьеэтэй тэмцэх ажилд үлэмж бэрхшээл учрах болсон.

Сүрьеэ өвчин хэрхэн тархдаг вэ?

Уушигны халдвартай хэлбэрийн сүрьеэтэй өвчтнөөс бусад хүнд агаараар дамжин халдварладаг. Халдвартай хэлбэрийн сүрьеэтэй хүн ярих, ханиах, найтаах, дуулах үед сүрьеэгийн нян агаарт цацагдаж түүний ойр орчимд байсан эрүүл хүн энэхүү сүрьеэгийн нян агуулсан агаараар амьсгалснаар халдвар авна.

Сүрьеэгийн нян агуулсан агаарыг амьсгалсан хүний уушгинд нян орж үржиж эхэлнэ. Тэндээс цусны урсгалаар дамжин биеийн бусад хэсэг болох бөөр, нуруу, тархинд



очно. Уушгинд байгаа сүрьеэ нь халдвартай юм. Энэ тохиолдолд сүрьеэгийн нян бусад хүмүүст тархана. Биеийн бусад хэсэг болох бөөр, нуруу зэрэгт байгаа сүрьеэгийн нян нь ихэвчлэн халдваргүй байна.

Халдвартай хэлбэрийн сүрьеэтэй хүн өдөр бүр хамтдаа ихэнх цагаа өнгөрүүлдэг хүмүүст халдвараа тараадаг. Эдгээр хүмүүст гэр бүлийн гишүүд, найз нөхөд, ажлын газрын хүн, нэг ангийн найзууд багтана.

Сүрьеэгийн халдварлалт гэж юу вэ?

Сүрьеэгийн нян агуулсан агаараар амьсгалснаар халдвар авах бөгөөд биеийн дархлалын системийн үйл ажиллагаа нь нянгийн үржлийг зогсоодог. Энэ үед сүрьеэгийн нян идэвхгүй хэлбэрт орсон ч тэд хүний биед амьд үлдэж, дараа нь идэвхтэй хэлбэрт шилжиж чаддаг. Энэ тохиолдлыг сүрьеэгийн халдварлалт гэнэ.

Сүрьеэгийн халдвар авсан хүнд ямар нэгэн шинж тэмдэг илрэхгүй, шаналахгүй, бусдад халдвар тараахгүй. Зарим хүмүүст бусад шалтгааны улмаас дархлалын системийн үйл ажиллагаа суларснаас хэдэн жилийн дараа ч сүрьеэгээр өвчилж болно.

Сүрьеэгийн өвчлөл гэж юу вэ?

Хэрвээ хүний дархлалын системийн үйл ажиллагаа суларсан тохиолдолд сүрьеэгийн нянгийн ургалтыг зогсоож чадахгүйгээс сүрьеэгийн нян идэвхтэй байдалд шилжинэ. Хүний биед сүрьеэгийн нян үржиж идэвхтэй байдалд орж сүрьеэ өвчин үүснэ. Энэ үед сүрьеэгийн нян биеийн эдийг гэмтээнэ. Хэрвээ энэ байдал уушгинд тохиолдвол уушгинд хөндий үүснэ.

Эмэнд мэдрэг сүрьеэгээр өвчилсөн хүмүүсийн өврийн павлах

Дараах хүмүүст дархлалын систем сул байдаг.

Үүнд:

- ХДХВ халдвар
- Чихрийн шижин
- Кортикостероид болон дархлаа дарангуйлах эмчилгээ удаан хугацаагаар хийлгэх (ясны чөмөг болон эрхтэн шилжүүлэн суулгасан)
- Бөөрний архаг дутагдал
- Цусны зарим эмгэг (лейкемия, лимфома)
- Бусад өвөрмөц хавдар
- Хэт туранхай (биеийн жингийн 10%-тай тэнцэх)
- Уушиг тоосжих өвчин
- Өлөн, цутгалан гэдэсний залгаас хийлгэсэн

Биеийн аль хэсэгт сүрьеэгийн нян байрлан өсөж үржиж байгаагаас хамааран шинж тэмдэг илэрнэ. Сүрьеэгийн нян уушгинд байрласан байвал:

- 2 ба түүнээс дээш долоо хоногоор ханиах
- Цээжээр өвдөх
- Цустай эсвэл цэртэй ханиах (уушигны гүнээс цэртэй)

Сүрьеэгийн үед илрэх бусад шинж тэмдэг

- Ядрах, сульдах
- Жин буурах
- Хоолны дуршил буурах
- Даарах
- Халуурах
- Шөнө хөлрөх



**Сүрьеэгийн халдвар болон сүрьеэгийн
өвчлөлийн ялгаа
Сүрьеэгийн халдварлалт**

Сүрьеэгийн халдвартай хүн

- Өвдөж шаналахгүй
- Шинж тэмдэг илрэхгүй

Сүрьеэгийн өвчтэй хүн

- Ихэвчлэн өвдөж шанална.
- Дараах шинж тэмдэг илэрнэ

- 2 ба түүнээс дээш долоо хоногоор муухай ханиах
- Цээжээр өвдөх
- Цустай эсвэл цэртэй ханиах
- Ядрах сульдах
- Жин буурах
- Хоолны дуршил буурах
- Даарах
- Халуурах
- Шөнө хөлрөх

- Бусдад хадвар тараахгүй

- Бусдад халдвар тараана.

- Цээжний зураг хэвийн, түрхэцийн шижилгээ сөрөг

- Цээжний зураг хэвийн биш, түрхэц болон өсгөврийн шинжилгээ эерэг

- Эмчлэх шаардлагагүй

- Эмчлэх шаардлагатай

Эмэнд мэдрэг сүрьеэгээр өвчилсөн хүмүүсийн өврийн павлах

Сүрьеэгийн сорил тавих хэрэгтэй юу?

Та дараах тохилдолд сүрьеэгийн сорил тавиулах хэрэгтэй.

➤ Уушигны халдвартай хэлбэрийн сүрьеэтэй гэж сэжиглэж байсан хүнтэй удаан хугацаагаар хамт байсан бол

➤ ХДХВ халдвартай болон сүрьеэгийн эрсдэл өндөртэй хүмүүстэй хамт байсан бол

➤ Сүрьеэгийн шинж тэмдэг илэрсэн эсвэл сүрьеэгийн өвчлөл өндөртэй улс орнуудад аялсан бол


Хэрвээ та сүрьеэгийн халдвар саяхан авсан байвал сүрьеэгийн сорил хараахан эерэг дүн гарахгүй байж болно. Та сүрьеэгийн халдвартай хүнтэй хамт байсан сүүлийн хугацаанаас хойш 8-10 долоо хоногийн дараа 2 дахь сорилыг тавина. Энэ нь халдварын дараах хүний дархлалын систем сүрьеэгийн сорилд хариу урвал өгөх хугацаа юм. Хэрвээ таны 2 дахь удаагийн сорил сөрөг бол магадгүй та сүрьеэгийн халдвар аваагүй байгаагийн илрэл юм.

Сүрьеэгийн халдварыг илрүүлэх ямар сорил байдаг вэ?

Сүрьеэгийн халдварыг илрүүлэх зорилгоор хүүхдэд сүрьеэгийн арьсны сорил тавина. Энэ сорилыг эрүүл мэндийн байгууллагад бэлтгэгдсэн эрүүл мэндийн ажилтан тавина. Таны гарны шуу хэсгийн арьсан дотор бага хэмжээгээр сорилын шингэнийг тарина. 3 өдөр буюу 72 цагийн дараа арьсны сорилыг эрүүл мэндийн ажилтан уншина. Таны сорил тарьсан газар хавдсан байна. Эрүүл мэндийн ажилтан хавдсан хэсгийн урвал өгсөн байдалд хэмжилт хийнэ. 10 мм-ээс дээш

Эмэнд мэдрэг сүрьеэгээр өвчилсөн хүмүүсийн өврийн павлах

хэмжилтэнд эерэг гэсэн хариу бичиж халдвартай хэлбэрийн сүрьеэтэй хүнээс сүрьеэгийн халдвар авсан гэж үздэг.



Сүрьеэгийн арьсны сорил эерэг байвал та юу хийх вэ?

Хэрвээ таньд тавьсан сүрьеэгийн сорилын хариу эерэг урвал өгсөн бол эмч, сувилагч таныг сүрьеэг илрүүлэх бусад шинжилгээг хийнэ. Энэ шинжилгээ нь ихэвчлэн цээжний рентген зураг юм. Мөн ханилгаж байгаа бол цэрний шинжилгээ өгнө. Эмч сувилагч нь уушигнаас бусад хэсгийн сүрьеэгийн нянг биеийн цус, шээсэнд тодорхойлно. Хэрвээ та сүрьеэтэй гэж оношлогдвол сүрьеэг эмчлэх эмийг уух хэрэгтэй.

Хэрвээ та БЦЖ вакцин хийлгэсэн бол яах вэ?

БЦЖ гэдэг нь сүрьеэгийн эсрэг вакцин юм. БЦЖ вакциныг хүүхэд төрсний дараа 24 цагийн дотор хийдэг. Гэвч вакциныг хийлгэснээр сүрьеэ өвчин үүсэхээс сэргийлж чадахгүй, харин сүрьеэгийн хүнд хэлбэрүүдээс найдвартай сэргийлнэ.

Хэрвээ та БЦЖ вакцин хийлгэсэн бол сүрьеэгийн сорил эерэг гарна. Энэ урвал нь БЦЖ вакцины улмаас

Эмэнд мэдрэг сүрьеэгээр өвчилсөн хүмүүсийн өврийн павлах

эсвэл сүрьеэгийн халдварын улмаас үүснэ.

Хэрвээ энэ урвал нь сүрьеэгийн халдварын улмаас үүссэн бол дараах тохиолдлыг авч үзнэ.

➤ Уушигны халдвартай хэлбэрийн сүрьеэтэй өвчтөнтэй одоо хамт байгаа, эсвэл

➤ Сүрьеэгийн тархалт өндөртэй улс орноос ирсэн, эсвэл

➤ Сүрьеэгийн халдвар ихтэй газарт байсан (орон гэргүй, хорогдох газар, эмнэлэг, шорон)

Хэрвээ сүрьеэгийн халдвартай бол сүрьеэ өвчин үүсэхээс хэрхэн сэргийлж болох вэ?

Ихэнх хүмүүст сүрьеэгийн халдвар нь сүрьеэгийн өвчлөл болохгүй. Гэвч зарим сүрьеэгийн халдвартай хүмүүст бусдаас илүү сүрьеэ өвчин үүсдэг.

Дараах тохиолдолд сүрьеэ өвчин үүсэх эрсдэл өндөр байдаг.

➤ ХДХВ халдвартай хүмүүс

➤ 2 жилийн хугацаанд халдвартай хэлбэрийн сүрьеэтэй хүнтэй хамт байсан

➤ Хүүхэд болон залуу насны хүмүүс

➤ Дархлалын систем сул болон бусад өвчтэй хүнтэй хамт байсан

➤ Өндөр настан

➤ Өмнө нь сүрьеэгийн эмчилгээг гүйцэд хийлгээгүй хүмүүстэй хамт байсан

Халдвартай хэлбэрийн сүрьеэтэй өвчтний хавьтал 5 хүртэлх насны хүүхдэд сүрьеэгийн арьсны сорилын

Эмэнд мэдрэг сүрьеэгээр өвчилсөн хүмүүсийн өврийн павлах

урвал 10мм-ээс дээш хэмжээтэй гарч эмнэлзүй, бусад шинжилгээгээр сүрьеэ үгүйсгэгдсэн тохиолдолд урьдчилан сэргийлэх эмчилгээг изониазидаар өдөрт 10мг/кг-аар бодож эмчилгээг 6 сар хийнэ.

Халдвартай хэлбэрийн сүрьеэтэй өвчтний ойрын хавьтал, сүрьеэтэй нь батлагдаагүй ХДХВ-ийн халдвартай хүнийг урьдчилан сэргийлэх изониазид эмчилгээг өдөрт 300мг-аар тооцон 6-9 сар хийнэ.

Хэрвээ эмч эмнэлгийн ажилтан энэ эмийг уух зааварчилгаа өгсөн бол сүрьеэ өвчин үүсэхээс таныг урьдчилсан сэргийлж байгаа юм.

Сүрьеэгийн халдварын үед сүрьеэгийн нян бага байдаг учраас сүрьеэ өвчнийг эмчлэхээс хялбар байдаг.



Хэрвээ та изониазидын эмчилгээг эхэлсэн бол эмч эмнэлгийн ажилтны хяналтан дор тогтмол цагийн хуваарьтай уух хэрэгтэй. Зарим хүмүүст изониазидын эмчилгээний үед гаж нөлөө илэрдэг.

Дараах гаж нөлөө илэрсэн бол та эмч эмнэлгийн ажилтанд яаралтай хэлээрэй

- Хоолонд дургүй болох
- Дотор муухайрах
- Бөөлжих
- Нүд, арьс шарлах
- 3 ба түүнээс дээш хоногоор халуурах
- Хэвлийгээр өвдөх
- Хөл гарын хуруу жирвэгнэх

Сүрьеэгийн халдвартай хүн бүр идэвхтэй сүрьеэгийн шинж тэмдгийг мэдэж байх хэрэгтэй. (Хуудас 7) Сүрьеэ

Эмэнд мэдрэг сүрьеэгээр өвчилсөн хүмүүсийн өврийн павлах

өвчний шинж тэмдэг илэрвэл эмч эмнэлгийн ажилтанд заавал хэлээрэй.

Уушигны халдвартай хэлбэрийн сүрьеэтэй хүнтэй хамт байсан бол та бусдад сүрьеэгийн халдвар тараах уу?

Уушигны халдвартай сүрьеэтэй хүнтэй хамт байсан бол сүрьеэгийн халдвар авах магадлалтай ч харин та бусдад сүрьеэгийн халдвар тараахгүй. Зөвхөн халдвартай сүрьеэтэй хүн бусдад халдвараа тараана. Халдвартай сүрьеэтэй хүний агаарыг амьсгалснаар сүрьеэгийн халдвар авна. Халдварлагдсан бие дэх сүрьеэгийн нян үржин олширч сүрьеэ өвчин үүсэх шалтгаан болно. Ингэснээр сүрьеэгийн нянг бусдад халдвар тараана.

Сүрьеэг хэрхэн эмчлэх вэ?

Хэрэв та шинжилгээгээр сүрьеэгээр өвчилсөн нь батлагдвал айж сандрах хэрэггүй. Учир нь сүрьеэгийн эсрэг эмчилгээг эмчийн зааврын дагуу тасралтгүй зөв горимоор нь хийлгэсэн тохиолдолд сүрьеэ өвчин төгс эдгэрэх боломжтой. Сүрьеэгийн эсрэг эмчилгээнд хэд хэдэн төрлийн эмийг хавсруулан ууж хэрэглэдэг.



Сүрьеэ өвчний эсрэг эмчилгээг эмч, эмнэлгийн

Эмэнд мэдрэг сүрьеэгээр өвчилсөн хүмүүсийн өврийн лавлах

ажилтан, эрүүл мэндийн сайн дурын ажилтны хяналтан дор 6-8 сар хийлгэдэг.

Сүрьеэгийн эсрэг эмчилгээ нь хоёр үе шаттай явагддаг.

➤ Эрчимт эмчилгээний шат

Энэ шатанд идэвхтэй байгаа сүрьеэгийн нянгуудыг бүрэн устгана.

➤ Үргэлжлэх хугацаа 2-3 сар

Үргэлжлэх шатны эмчилгээ нь 4-6 сарын хугацаатай үргэлжилнэ.

Эмч эмнэлгийн ажилтны хяналтан дор хэд хэдэн төрлийн эмээр эмчлэх шаардлагатай. Эдгээр эм нь маш олон тооны сүрьеэгийн нянг устгах, эмэнд дасалтай сүрьеэгийн нян үүсэхээс урьдчилан сэргийлэх учраас хэд хэдэн төрлийн эм байгаа юм

Сүрьеэгийн эмчилгээнд дараах эмүүдийг түгээмэл хэрэглэдэг.

- Изониазид (INH)
- Рифампицин (RIF)
- Этамбутол (Eth)
- Пиразинамид (Z)
- Стрептомицин (S)

Хэрвээ та уушигны болон цагаан мөгөөрсөн хоолойн сүрьеэтэй бол бусдад халдвар тараах эрсдэлтэй. Ажил, хичээлд явдаг бол бусад хүмүүст халдвар тараахгүйн тулд гэртээ байх нь чухал юм. Хэдэн долоо хоног эмээ уусны дараа таны биеийн байдал сайжирч та бусдад халдвараа тараахгүй болно. Эмч эмнэлгийн ажилтан таныг хэзээ ажил, хичээлд явах, найз нөхөдтэйгээ уулзахыг хэлж өгөх болно.

Сүрьеэ өвчтэй байх нь таны хэвийн амьдралыг өөрчлөхгүй. Халдвартай байх, биеийн байдал муу байх нь урт хугацаанд үргэлжлэхгүй учраас та өвчлөхөөс өмнө хийж

Эмэнд мэдрэг сүрьеэгээр өвчилсөн хүмүүсийн өврийн павлах

байсан бүх зүйлсээ бүгдийг хийж болно.

Сүрьеэгийн эмийг ууснаар таны хүч чадал, бэлгийн үйл ажиллагаа, ажиллах авъяас чадвар зэрэгт нөлөөлөхгүй

Та эмч эмнэлгийн ажилтны хяналтанд эмээ тогтмол уух нь сүрьеэгийн бүх нянг устгана.

Сүрьеэгийн эмийн гаж нөлөө гэж юу вэ?

Хэрвээ та сүрьеэгийн эм ууж байгаа бол эмч эмнэлгийн ажилтны шууд хяналтан дор эмээ уух хэрэгтэй. Сүрьеэгийн эмчилгээ хийлгэж байгаа үед эмийн гаж нөлөө илэрдэг. Хэрвээ таньд дараах эмийн гаж нөлөө илэрвэл яаралтай эмч эмнэлгийн ажилтанд шууд мэдэгдээрэй.

Хоолонд дургүй болох

- Дотор муухайрах
- Бөөлжих
- Нүд, арьс салст шарлах
- 3 ба түүнээс дээш хоногоор халуурах
- Хэвлийгээр өвдөх
- Гар хөлийн хуруу жирвэлзэх
- Арьс улайх
- Цус амархан гардаг болох
- Үе мөч өвдөх
- Толгой эргэх
- Амны эргэн тойрон жирвэгнэх
- Хараа өөрчлөгдөх
- Чих дүнгэнэх
- Сонсгол муудах



Эмэнд мэдрэг сүрьеэгээр өвчилсөн хүмүүсийн өврийн павлах

Таньд доорхи жагсаалтанд байгаа гаж нөлөө илэрвэл эмээ үргэлжлүүлэн уугаарай

➤ Рифампицин эм ууж байгаа болохоор шээс, шүлс, нулимс улбар шар өнгөтэй болж өөрчлөгдөнө. Эмч эмнэлгийн ажилтан таньд зөөлөн контакт линз зүүхгүй байхыг зөвлөнө.

➤ Рифампицин эм нь наранд маш их мэдрэг болгодог. Иймд та нарнаас хамгаалах тос хэрэглэхийг зөвлөж байна.

➤ Рифампицин эм нь төрөлтөнд бага нөлөөтэй.

Яагаад сүрьеэгийн эмийг тогтмол уух шаардлагатай вэ?

Сүрьеэгийн нянг бүрэн устгахад дор хаяж 6 сар шаардагддаг. Магадгүй таньд эмчилгээ эхэлснээс хэдхэн долоо хоногийн дараагаас бие чинь сайжирч зовиур шаналгаа арилсан мэт санагдаж болно. Гэвч сүрьеэгийн нянгууд таны биед амьд байсаар л байгаа гэдгийг мартаж болохгүй. Эмээ тогтмол уугаагүйгээс сүрьеэгийн нян дахин идэвхжин өмнөхөөсөө ч удаан хугацаагаар өвчлөх, эмэнд тэсвэртэй болох аюултай үр дагавартай. Ийм тохиолдолд гаж нөлөө ихтэй өөр олон төрлийн эмүүдийг удаан хугацаагаар уух шаардлагатай болно.

Энэ үед өвчин сэдэрч гэр бүл, найз нөхөд, таны эргэн тойрны хүмүүст дахин халдвар тарааж эхэлдэг. Иймээс эмчийн зааврын дагуу эмч, эмнэлгийн ажилтан, эрүүл мэндийн сайн дурын ажилтны хяналтан дор эмээ тогтмол уух нь чухал юм.

Шууд хяналттай богино хугацааны эмчилгээ (ДОТС) гэж юу вэ?

Таны эмчилгээг шууд хяналттай өгөхийг санаж байх хамгийн сайн арга бол ДОТС юм. Эмч эмнэлгийн ажилтан тантай өдөр бүр уулзаж таньд эмийг харж уулгахыг ДОТС гэж нэрлэнэ.

Таныг эмчилгээгээ тасралтгүй зөв, тогтмол хийлгэхэд тань үзүүлж буй тусламж юм. Мөн эмчилгээний үед илэрсэн эмийн гаж нөлөөг арилгахад таньд тусална.

Мөн сүрьеэгийн эсрэг эмчилгээ хийлгэж буй зарим хүмүүс эмийн үйлдлийн эхний нөлөөнд хууртаж зовиур шаналгаа арилмагц эдгэрлээ гэж бодон эмчилгээгээ зогсоодог. Энэ нь сүрьеэгийн нянгуудыг бүрэн устгаж чадалгүй харин ч эмэнд тэсвэртэй болгож амь насанд аюул учруулна.



Та эмээ уухаа мартахгүйн тулд юу хийх вэ?

➤ Эмийг өдөр бүр тогтсон цагт ууж байх, энэ талаар эмчлэгч эмч, сувилагч нартайгаа сайтар ярилцаж цагаа тохирох

➤ Гэр бүлийн гишүүдийн хэн нэгэн эмээ уухыг тогтмол сануулж байх

➤ Гар утас дээр эмээ уух цагаа тохируулж дуут дохио тавих

➤ Эсвэл цаг дээр эмээ уух цагаа тохируулж сэрүүлэг тавих

➤ Та ажлын өрөө, ширээ, гэртээ эмээ уухаа сануулсан тэмдэглэлийг хуанли дээр хийж болно

➤ Та гал тогоо, ариун цэврийн өрөөнд эмээ уухыг сануулсан ямар нэг тэмдэглэл тавьж болно. Энэхүү гарын авлагын хавсралтанд эмээ ууснаа тэмдэглэх хэсэгт өдөр бүр эмчилгээ хийлгэсний дараа тосон балаар бичиж байгаарай

Сүрьеэ өвчин тархахаас хэрхэн сэргийлэх вэ?

Сүрьеэгийн халдвар тараахаас сэргийлэх хамгийн сонгодог арга бол эмчийн зааврын дагуу бүх эмээ горимын дагуу уух явдал юм.

Сүрьеэгийн эмчилгээний үр дүнг хянах гол арга нь цэрний түрхэцийн шинжилгээ юм. Цэрний шинжилгээ өгөх нь таны эмийн үйлчилгээ болон бусдад халдвар тарааж байгаа үгүй эсэхийг харуулна.

➤ Эмчилгээний бүлэг, горимоос хамаарч тодорхой саруудад эмчилгээ хяналтын цэрний шинжилгээг хийдэг. Хэрэв та 1-р бүлгээр эмчлэгдэж байгаа бол эмчилгээний 2,5,6 дахь саруудад

➤ 2-р бүлгээр эмчлэгдэж байгаа бол эмчилгээний 3,5,8 дахь саруудад тус тус цэрний шинжилгээ өгнө. Мөн эмчилгээний төгсгөлд рентген шинжилгээ хийж биеийн байдлыг тодорхойлно.

Танд ямар нэгэн зүйл болохгүй байна гэж бодож байгаа бол эмчдээ заавал хэлээрэй. Та эмээ горимын дагуу тасралтгүй тууштай ууж байгаа бол хэдэн долоо хоногийн дараа гэхэд халдвар ялгаруулахаа болино.

Хэрвээ та халдвартай хэлбэрийн сүрьеэтэй бол гэр бүлээ, өөрийн ойролцоо байгаа хүмүүсээ хамаалах хэрэгтэй.



- Эмээ шууд хяналттай уух хэрэгтэй. Энэ бол хамгийн чухал!
- Ханиах, найтаах, инээх үедээ амны алчуур, цаасан алчуураар амаа дарах хэрэгтэй. Хэрэглэсэн цаасан алчуураа тагтай хогийн саванд хаях хэрэгтэй
- Ажил, хичээлдээ явахгүй байх. Хэн нэгэнтэй ойр

Эмэнд мэдрэг сүрьеэгээр өвчилсөн хүмүүсийн өврийн павлах

байхаас зайлсхийх, бусдаас өөрийгөө тусгаарлах хэрэгтэй. Бусад гэр бүлийн гишүүдээс тусдаа унтлагын өрөөнд унтах хэрэгтэй.

• Өөрийн байрлаж байгаа өрөөндөө гаднаас агаар тогтмол оруулж байх хэрэгтэй. Өрөөний цонхондоо агаар гаргах сэнс суурилуулж болно.



Дахин сүрьеэгээр өвчлөхгүйн тулд юуг анхаарах ёстой вэ?

Хэдийгээр сүрьеэгийн эмчилгээ хийлгэж эдгэрсэн ч дахин өвчлөх магадлалтай.

- Амин дэм, тэжээллэг сайтай хоол хүнс хэрэглэх
- Ажил, амралтаа зохицуулах, харанхуй чийгтэй орчин хүйтэн нөхцөлд ажиллахаас зайлсхийх
- Өрөө тасалгаагаа байнга агааржуулж нар, салхи оруулах, биеийн эсэргүүцлээ сулруулахгүй байх
- Биеийн тамираар хичээллэх, эрүүл агаарт амрах нь чухал
- Сэтгэл санаагаар өөдрөг байх, стресст өртөхгүй байх нь өвчин дахихаас сэргийлэхэд тустай
- Ямар зовиур шаналгаа илэрсэн үед эмчид даруй хандах хэрэгтэй
- Архи тамхи зэрэг хорт зуршлаас татгалзах нь таны эрүүл мэнддээ оруулж буй том хувь нэмэр юм.

Хэрэв та энэхүү гарын авлагад багтсан мэдээллийг өөрийн болгож амьдралдаа мөрдлөгө болгож чадвал **ТИЙМ ЭЭ, ТА БҮРЭН ЭДГЭРНЭ.**

Үйлчлүүлэгчийн овогнэр.....нас.....хүйс.....

Гэрийн хаяг.....

.....

Ажил, сургуулийн хаяг.....

.....

Биеийн жин.....Ам бүлийн тоо.....

Эмчилгээ эхэлсэнон.....сар.....өдөр. Эмээ ууснаа тэмдэглэх хүснэгт

Эмэнд мэдрэг сүрьеэгээр өвчилсөн хүмүүсийн өврийн павлах

Эмчилгээ эхэлсэнон.....сар.....өдөр. Эмээ ууснаа тэмдэглэх хүснэгт

өдөр	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар
1								
2								
3								
4								
5								
6								
7								
8								
9								
10								
11								
12								
13								
14								
15								
16								
17								
18								
19								
20								
21								
22								
23								
24								
25								
26								
27								
28								
29								
30								
31								

Тайлбар: Та эмээ шууд хяналттай буюу эмч сувилагчийн дэргэд уугаад уусан сарын өдрийн харалдаа нүдэнд "Х" гэж тосон балаар тэмдэглээрэй.

